



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

Г “Практикал даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн 7 хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Практикал даатгал” ХХК-ийн дүрмийн санг нэг бүр нь 10000.0 /арван мянган/ төгрөгийн үнэ бүхий нийт 60000 /жаран мянган/ ширхэг хувьцаагаар нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгчдийн нэрс	Дүрмийн сангийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Тардай овогтой Гантөмөр	500 000 000	600 000 000	1100 000 000	100,0
	Нийт	500 000 000	600 000 000	1100 000 000	100,0

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Практикал даатгал” ХХК /Ч.Даваажав/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН